

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/07

Арвайхээр

Өндөржүүлсэн бэлэн байдлын
зэрэгт шилжүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/93 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай” А/55 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн өндөржүүлсэн бэлэн байдлыг цуцлах хүртэлх хугацаанд эрүүл мэндийн байгууллагуудыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт эрүүл мэндийн байгууллагын ажиллах горимыг хавсралтаар баталсугай.

3. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед байгууллага, салбар, нэгжийн хэмжээнд ажиллах шуурхай штаб байгуулан, 24 цагаар ажиллах хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулж, мэдээг өдөр бүр 19 цагт Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрт мэдээлэхийг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Зооноз өвчин судлалын төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт даалгасугай.

4. Энэхүү тушаалыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд мөрдөн ажиллаж, албан хаагчдад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр чөлөө олгохгүй байх, холбоо барих утсыг байнга нээлттэй байлгахыг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Зооноз өвчин судлалын төв, Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа)-д, хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА




Д.ШИВААННҮРДЭВ

018900017

D:\My Doc.A4 tushaal /EMG/

ЭМГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын
17...-ны өдрийн 4107 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



ӨНДӨРЖҮҮЛСЭН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ГОРИМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1-10.4.5, 11 дүгээр зүйлийн 11.3.4, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2020 оны “Удирдамж батлах тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор эрүүл мэндийн байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдлын горимд шилжүүлэн ажиллуулах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эрүүл мэндийн байгууллага нь энэхүү горимыг үндэслэн тухайн орон нутаг, байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиг үүрэгт нийцүүлэн өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах төлөвлөгөө батлан, хэрэгжүүлж ажиллах бөгөөд энэ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байна.

Хоёр. Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл

2.1. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн талаар байгууллагын ажилтан, албан хаагчдад танилцуулан, үүрэг чиглэл өгч, зохион байгуулалтын арга хэмжээ авна.

2.2. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед гарсан шийдвэр, үүрэг, чиглэлийг тухай бүр хэрэгжүүлж ажиллана.

2.3. Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах нөөц бүрдүүлэх, зарцуулах төлөвлөлтийг хийнэ.

2.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, эмнэлгийн ор дэлгэх, тусад нь эмнэлэг нээж ажиллуулах бэлтгэлийг хангана.

2.5. Байгууллага бүр бэлэн байдлын горимд ажиллах төлөвлөгөөндөө дараах үйл ажиллагааг нэмэлтээр тусган, баталж, мөрдөнө.

2.5.1. Үйлчлүүлэгч бүрийг угтан, халууныг нь хэмжиж, амны хаалт хэрэглүүлэх, сэжигтэй тохиолдлыг илрүүлж, зааврын дагуу ажиллана.

2.5.2. Байгууллагын дотоод хөдөлгөөний урсгалыг зохицуулж, эмчлүүлэгчийн сахиур, ар гэрийн эргэлтэд хязгаарлалт хийнэ.

2.5.3. Хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл, ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж ажиллана.

2.5.4. Шаардлагатай тохиолдолд энгийн хамгаалах хувцас, хэрэгсэл, амны хаалтыг бэлтгэх, нөөц бүрдүүлэхэд орон нутгийн Засаг дарга, нутгийн удирдлагын байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийг дайчлан, хамтран ажиллана.

2.5.5. Өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах дадлага, сургалтыг зохион байгуулж, ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулна.

2.5.6. Ажилтан, албан хаагчдын ажил, үүргээ гүйцэтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх, хоол хүнс, хувцас, техник хэрэгслээр хангах, аюулгүй ажиллагааг сахиулах, эрүүл мэндэд анхаарч ажиллана.

2.5.7. Байгууллагын ариун цэврийн өрөөний халдваргүйтгэлийг тогтмол хийж, үйлчлүүлэгчийн гараа угааж, халдваргүйжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2.5.8. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааг тогтмол хийж, зөвлөмж, сэрэмжлүүлгийг үйлчлүүлэгч бүрт түгээнэ.

2.6. Нөхцөл байдал болон удирдах шатны байгууллагын шийдвэрийг салбар нэгжийн удирдлага, ажилтан, албан хаагчдад тухай бүр мэдээлнэ.

2.7. Байгууллага, салбар, нэгжийн хэмжээнд ажиллах шуурхай штаб, жижүүрийг томилон удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

2.8. Нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Эрүүл мэндийн газарт тухай бүр шуурхай танилцуулна.

2.9. Бодит байдлын талаар орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай мэдээлж, буруу ташаа мэдээллийг тухай бүрт нь залруулна.

2.10. ЭМГ-ын даргын 2 сарын 14-ний өдрийн 107 дугаар албан бичгээр хүргүүлсэн хавсралт маягтуудын дагуу мэдээг нэгтгэн, ЭМГ-ын хариуцлагатай жижүүрт цахим хаягаар ирүүлнэ.

2.11. Өдөр бүр шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх илтгэх хуудсыг ЭМГ-ын хариуцлагатай жижүүрт 17:00 цагаас өмнө цахимаар ирүүлнэ.

Гурав. Бусад

3.1. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллах үед хариуцсан ажилдаа идэвх зүтгэл гарган үр дүнтэй ажилласан ажилтан, албан хаагчдыг шагнаж урамшуулна.

3.2. Өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ, эрх, үүргийг зөрчсөн ажилтан, албан хаагчдыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.